



**МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/671

Хэрлэн сум

**Аймгийн 2022 онд онцлох амжилт  
гаргасан байгууллага, аж ахуй нэгжийг  
шалгаруулах арга хэмжээнд  
хөрөнгө зарцуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 онд онцлох амжилт гаргасан байгууллага, аж ахуй нэгжийг шалгаруулах үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар сарын 27-д Чингис хотод зохион байгуулсугай.

2.Үйл ажиллагаанд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022  
оны 12 дугаар сарын 23-ны  
дугаар захирамжийн хавсралт

Үйл ажиллагаанд шаардагдах төсөв

Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	тоо ширхэг	Нийт үнэ
ХХЧ-ын цахилгааны бэлэн байдлыг хангахад шаардагдах түлш	3760	60л	225,600
Хөөсөнцөр	40,000	8 ш	320,000
Утааны шингэн			845,100
Стикер хэвлэл			470,000
Ажлын хөлс	160,000	3	480,000
Нийт үнэ			2,340,700